

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

1.1. Ерөнхий мэдээлэл:

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрыг байгуулж Соёлын сайдын 2022 оны А/04 дүгээр тушаалаар тус газрын зохион байгуулалтын бүтэц, дүрмийг баталсан.

➤ Соёлын сайдын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн Б/13 дугаар тушаалаар Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газрын дарга томилогдож, 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдөр ажлаа хүлээн авснаар албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

➤ Соёлын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний А/04 тоот тушаалаар тус газар нь Захиргаа, удирдлагын хэлтэс, Соёл, урлагийн хэлтэс гэсэн 2 нэгжтэйгээр, бүтэц, орон тооны хувьд **11** ажилтан, албан хаагч ажиллахаас удирдах албан тушаалтан 1, төрийн захиргааны **5**, төрийн үйлчилгээний **2** буюу нийт **8** орон тоотойгоор үйл ажиллагаагаа явууллаа.

➤ Тус газрын **8** албан хаагч 2022 оны жилийн эцсийн байдлаар нийтдээ **144** хүн/өдөр ажиллахаас **144** хүн/өдөр ажилласан байна. Үүнээс өвчтэй, чөлөөтэй байхгүй.

1.2. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Соёлын яамнаас зохион байгуулсан Удирдах ажилтны зөвлөгөөнд аймгийн СУГ-ын дарга оролцож, байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагчаар хянуулж гэрээ байгуулсан. Мөн 6 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж төрийн үйлчилгээний 2 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллалаа.

Тайлант хугацаанд газрын дарга **41** тушаал гаргасан ба шийдвэрийн биелэлт бүрэн хэрэгжсэн. Үүнээс **15** нь хүний нөөцийн асуудлаар, **26** нь үндсэн үйл ажиллагааны асуудлаар гаргасан шийдвэр байна.

Газрын өдөр тутмын болон хяналт шалгалтын ажлыг байнгын удирдлагаар хангах зорилгоор газрын шуурхай хуралдааныг **7** хоног тутам буюу нийтдээ **33** удаа /ээлжит 29, ээлжит бус 4/ зохион байгуулж, **36** асуудал хэлэлцэж, эдгээрээс өгөгдсөн **23** үүрэг даалгаврыг бүрэн биелүүлжээ.

Соёлын яамнаас зохион байгуулсан цахим хурал, сургалтуудад нийтдээ 20 удаа оролцон, хурлаас өгөгдсөн нийт **15** үүрэг даалгавраас орон нутагт хамаарах **10** заалтаас биелэлт ирүүлэх шаардлагатай **8** заалтын хэрэгжилтийг цаг хугацаанд нь гаргаж цахимаар илгээж тайлагнасан.

Аймгийн ЗДТГ-ын шуурхай хуралд 7 хоног бүрийн Даваа гараг бүр 29 удаа, хэлтэс, агентлагийн дарга нарын хуралд 18 удаа оролцсон байна.

➤ Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд заасны дагуу тус газрын даргын 2022 оны А/21 дүгээр тушаалаар Ёс зүйн зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Уг зөвлөл нь нийт албан хаагчдад ёс зүйн дүрмийг сурталчлан таниулж, төрийн албан хаагчийн тангаргыг сэргээн танилцуулж, авлига, ашиг сонирхлоос ангид, ёс зүйн зөрчилгүй ажиллалаа.

1.3. Хүний нөөцийн үйл ажиллагааны талаар:

➤ Тус газрын бүтэц, орон тоог 2 нэгж, 11 орон тоотойгоор баталсан. Өнөөдрийн байдлаар Газрын дарга, төрийн захиргааны 5, төрийн үйлчилгээний 2 албан хаагч буюу нийт 8 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

➤ Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 535 дугаар тогтоолоор Соёл, урлагийн газрын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт батлах зөвшөөрөл олгосноор Тус газарт сул гарсан 6 орон тоог Төрийн албаны тухай хуульд заасны дагуу Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд албан бичгээр мэдэгдэж, зарлуулах арга хэмжээг авсан. Төрийн албаны тусгай шалгалтад 5 албан хаагч тэнцэж, 3 албан хаагчийг 6 сарын туршилтын хугацаатай, 2 албан хаагчийн ХАСУМ-ийг АТГ-аар хянуулж зөрчилгүй гэх дүгнэлтийг үндэслэн ахлах мэргэжилтнээр тус тус томилсон. Шинээр томилогдсон 2 албан хаагчийн ХАСХОМ-ыг хянан цаасан болон цахим бүртгэлд бүртгэн баталгаажуулсан.

➤ Тус газрын харъяанд Залуучууд театр, Музей, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Хонгор, Орхон, Шарын гол сумдын Соёлын төв зэрэг төрийн үйлчилгээний 7 байгууллага харъяалагдан соёл, урлагийн үйл ажиллагаа явуулдаг ба тэдгээрт нийт 155 соёл, урлагийн ажилтан ажиллаж байна. Соёлын салбарын 7 байгууллагын нийт батлагдсан орон тоо 158 болно. Үүнээс өнөөдрийн байдлаар ажиллаж буй 155 ажилтны 88 нь эмэгтэй, 67 нь эрэгтэй, мэргэжлийн боловсон хүчин 106 байна.

➤ Дархан-Уул аймаг дахь ТАЗСЗ-өөс тус газарт хүний нөөцийн аудит хийж 15 заалт бүхий зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг хугацаанд нь гаргаж тайлагнасан.

➤ АТГ-ын хяналт, шалгалтын ажлын хэсэг нь Дархан-Уул аймагт ажиллаж тус газрын хүний нөөцтэй холбоотой гарсан шийдвэрүүдийг хянасан. Зөрчилгүй дүгнэлттэй.

➤ Хүний нөөцийн бүртгэл мэдээллийн шинэчлэгдсэн цахим системд /ХНУМТ/ 8 албан хаагчийн мэдээллийг оруулж, хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгааг Соёлын яаманд 2 удаа гаргаж хүргүүлсэн.

1.4. Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны асуудлыг шийдвэрлэх чиглэлээр:

➤ Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулан “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын төслийг боловсруулан нийт албан хаагчдад танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгуулж хэлэлцүүлсний үндсэн дээр 5 зүйл, 12

хэсэг, 95 заалт бүхий журмыг тус газрын даргын 2022 оны А/20 дугаар тушаалаар батлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

➤ Ажил хөдөлмөрөөрөө бусдыгаа манлайлан ажилласан 1 албан хаагчийг салбарын шагналд, 1 албан хаагчийг аймаг, орон нутгийн шагналд тодорхойлж, холбогдох газруудад уламжилсан.

➤ Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу 1 албан хаагч шинэ хүүхэдтэй болсон тул 100.000 төгрөгийн төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн.

➤ Аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу цэцэрлэг, сургуулийн бага насны хүүхдүүдээ хүргэж өгөх, авах нөхцөлөөр 4 ажилтныг хангасан. Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 6 дугаар зүйлийн 6.9 дэхь заалтад оруулж батлав. Мөн 18 хүртэлх насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд хүүхдийн “Мэндэлсэн өдөр”-өөр цалинтай чөлөө олгох, цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхчүүдийг оролцох боломжоор хангах ажлуудыг тогтмолжуулсан. Тус үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн 2022 оны 11 дүгээр сарын 02-нд аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т тайланг хүргүүлэв.

➤ Төрийн албаны тухай хууль, Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журамд заасны дагуу зэрэг дэвийг нэмэгдүүлэх шаардлага хангасан албан хаагч байхгүй байна.

1.5. Хүний нөөцийг чадавхижуулах, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх чиглэлээр:

➤ 2022 оны 12 дугаар сарын байдлаар соёлын салбарын нийт 142 /давхардсан тоогоор/ ажилтан, албан хаагчдын 52 нь 11 удаагийн танхимын, 90 нь 20 удаагийн цахим сургалтад тус тус хамрагдсан байна. Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагчийг хамруулжээ.

➤ Аймгийн Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөлийг 25 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдөр батламжлав. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн 12 салбарын залуучуудын хөгжлийн 14 салбар зөвлөлийн төлөөлөл Соёлын сайдтай уулзалт хийхэд аймгаа төлөөлж оролцсон.

1.6. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

➤ Тайлант хугацаанд **5 журам, 1** стандартад нэмэлт өөрчлөлтөд оруулах санал өгсөн. Тухайлбал: “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах” журмын төсөл, аймгийн Захирагчийн албанд реклам, сурталчилгааны самбар байрлуулах түрээслүүлэх, түрээслэх журам, Архидан согтуурахтай тэмцэх, хяналт тавих аймгийн дэд хөтөлбөр зэрэгт соёлын салбарын ажилтнуудаас санал авч нэгтгэн хүргүүлсэн.

1.7. Хяналт, шинжилгээ, үнэлгээний талаар:

➤ Соёл, урлагийн газар нь 2022 онд байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг тоо хэмжээ, чанарын шалгуур үзүүлэлтээр гарган 98

хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үзүүлэлттэй тайлагнасан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн ажлын биелэлтийн үнэлгээ:

- 100 хувийн буюу “Үр дүнтэй” - 50 арга хэмжээ
- 70-99 хувийн буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” – 4 арга хэмжээ
- 31-69 хувийн буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” -1 арга хэмжээ
- 0 хувийн буюу “ үр дүнгүй” -0 арга хэмжээ байна.

➤ 2022 оны жилийн эцсийн байдлаар хуулийн холбогдох 15 заалтын хэрэгжилтийн дунджаар 91,3 хувиар хангуулсан.

1.8 Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар:

➤ Соёл, урлагийн газарт 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 172 албан бичиг ирсэн. Үүнээс хариутай албан бичиг 32, явуулсан албан бичиг 152 байна. Албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээг сар бүр гаргаж хэвшсэн. Тайлант хугацаанд байгууллага, иргэдээс өргөдөл гомдол ирээгүй.

1.9 Байгууллагын байр, нөхцөл байдал, санал:

➤ **Соёл, урлагийн газар** нь анх аймгийн ЗДТГ-ын 107 тоот өрөөнд байрлаж байгаад 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрөөс аймгийн Ахмадын хорооны байрны 2 дугаар давхрыг түр түрээслэж байна. Тус газраас 2023 онд түрээсийг үргэлжлүүлэх боломжгүй гэсэн тул өөр байр хайж байна. Аймгийн Засаг даргаас Мэргэжлийн хяналтын газар татан буугдахаар тус газрын байранд оруулахаар албан бусаар мэдэгдсэн. Гэвч аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь Дархан сумын ЗДТГ-ын байранд түрээсийн журмаар үйл ажиллагаа явуулдаг тул цаашид байрны асуудал тулгамдсан хэвээр байна. Соёл, урлагийн газрын ажилтнуудын хувьд ширээ сандал, компьютер, техник тоног төхөөрөмж дутагдалтай байна. Аймгийн ЗДТГ болон бусад төрийн байгууллагуудаас актлагдсан ширээг авч сэлбэн засаж түр ашиглаж байна.

➤ **Аймгийн Музей** нь 1968 оны 5 дугаар сард орон нутаг судлах кабинет нэртэйгээр байгуулагдаж 1969 оны 10 дугаар сард Дархан хотын Үйлчилгээний төв баригдахад одоогийн музейн байранд шилжин байрласан. Музейн байр 1000 м2 бүхий талбайтай бөгөөд үзмэрийн 4 танхимтай, 1362 гаруй сан хөмрөг, үзмэртэй. 55 жил зориулалтын бус байранд байрласан. Үзмэр дэглэлт зохион байгуулахад стандарт шаардлага хангахгүй тул тус аймагт Музей-Номын сангийн цогцолбор 2024 онд ашиглалтад орохоор баригдаж байна.

➤ **Залуучууд театр нь** нь Театрын барилга нь 1978 оны 12 дугаар сарын 28-нд ЗХУ-ын техник эдийн засгийн тусламжаар ашиглалтад орсон. 588 хүний суудалтай үзвэрийн их танхим, 100 хүний суудалтай хурлын бага танхим, 100 хүний суудалтай Хүүхэлдэйн театрттай. Бэлтгэлийн болон уран бүтээлчдийн өрөөтэй. Барилга байгууламжийн стандартыг бүрэн хангасан хэдий ч “чанартай, хүртээмжтэй, сэтгэл ханамжийн өндөр баталгаатай уран бүтээл” туурвих шаардлага хангахуйц техник тоног төхөөрөмж дутагдалтай хэвээр байна.

➤ **Төв номын сан** нь 120 гаруй уншигч хүлээн авах хүчин чадалтай 2 салбар номын сантай. Одоогийн номын сангийн барилга нь Залуучууд театрын барилгын нэгэн хэсэг. Стандартын шаардлага хангахгүй тавилга, тоног төхөөрөмж, үйлчилгээний орчин нөхцөл бүхий үйлчилгээний танхимуудтай. Архивын фонд /түүх соёлын ховор номын хадгалалт хамгаалалт/ зориулалтын биш, цахилгаан, дулаан, агааржуулалтын өрөө тасалгааны зохион байгуулалт стандарт бус.

➤ **Хүүхдийн номын ордныг** МУЗГ-ын 2000-2004 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Хүүхдийн Номын Ордон байгуулах тухай заалт тусгагдсаны дагуу 2003 онд 123,0 сая төгрөгийн төсөвт өртгөөр байгуулсан нь хөдөө орон нутагт анхдагч болсон юм. Уншлагын 2 танхим, Төрөлжсөн 4 танхим, Чөлөөт уншлагын 2 танхим, Хүүхэд хөгжлийн ордонд №101 тоотод Салбар номын сан 1 танхим (28 суудал, 2376 номтой), Зулзагын голын Хүүхдийн зусланд Нүүдлийн номын сан (явуулын 650-850 номтой), Төв байранд (124 суудал, 12600 гаруй номтой) Нэг ээлжиндээ 152 уншигч хүлээн авах боломжтой. (Тоо баримтыг 2022 оны 11-р сарын 30-аар тасалбар болгосон)

➤ **Шарын гол сумын Соёлын төв** нь 1965 онд байгуулагдсан. 250 хүний суудалтай урлаг, соёлын танхим, номын сантай. Сумын соёлын төвд орон нутгийн төсвийн 181.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар дотор их засвар хийсэн.

➤ **Орхон сумын соёлын төв** нь 1974 онд байгуулагдсан. 2022 оны жилийн эцсийн байдлаар 220 хүний суудалтай урлаг, соёлын танхим, номын сан, орон нутаг судлах танхим 20 ширхэг үзмэр, бусад / биллярд, теннис, заал/-аар нийт 7597 иргэдэд үйлчилсэн байна. Ашиглалтгүй байсан 14 өрөөг сумын ОНХС-гийн 285 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засварласан. Ингэснээр хурлын болон бүжгийн заал, шатар, даам, морин хуур, ёочин зэрэг дугуйлан секц хичээллэх бүрэн боломжтой болсон. Мөн соёлын төвийн дэргэд дуу бичлэгийн студи байгуулахаар нэг өрөөг тусгай акустик хавтангаар завсарлаж тохижуулсан.

➤ **Хонгор сумын соёлын төв** нь 1969 онд байгуулагдсан. 100 хүний суудалтай урлаг, соёлын танхим, номын сан, орон нутаг судлах танхим 94 ширхэг үзмэртэйгээр олон нийтэд үйлчилж үйл ажиллагаагаа явуулж байна.

Соёл, урлагийн байгууллагын нөөц:

/2022 оны суурь түвшин/

№	Байгууллагын нөөц	Тоогоор
1	Залуучууд театр /Мэргэжлийн урлагийн байгууллага/	1
2	Төв номын сан	1
	Салбар номын сан	1
	Архив	1

3	Хүүхдийн номын ордон		1
4	Аймгийн Музей	Музей	1
		Орон нутгийн судлах танхим	2
5	Сумдын соёлын төв		3
Нийт		5	12

**ХОЁР. АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРТ ТУССАН СОЁЛЫН БОДЛОГО,
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР:**

2.1. Соёлын сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг 2022 жилийн эцсийн байдлаар гаргаж аймгийн Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэхээр ажиллаж байна. Тухайлбал:

- Музей - Номын Сангийн цогцолбор 2021-2023 онд нийт 14,533,0 тэрбум төгрөгөөр баригдах бөгөөд 2022 онд барилгын эхний үе шатны ажлыг “Бокон” ХХК гүйцэтгэсэн. Эхний үе шатны ажил буюу суурийн ажил 100%. 1 давхарын угсралтын ажил дууссан. Тус ажлын гүйцэтгэлийн асуудлаар 2022 оны 10 дугаар сарын 02-ны өдөр захиалагч, гүйцэтгэгч талууд санал солилцох уулзалт хийж барилга угсралтын явцтай танилцлаа.
- Музей, номын сангийн цогцолборын үзэл баримтлал боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж судалгааны ажлыг эхлүүллээ. Ажлын хэсгийн ахлагч, зөвлөн туслах гишүүдэд 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр мэдээлэл өгөх, зөвлөлдөх уулзалт зохион байгуулав. Уулзалтаар Байгалийн түүхийн музейн сан хөмрөгийн хэлтсийн дарга, доктор Ж.Мяндас, Японы соёлын өвийн гадаад хамтын ажиллагааны консорциумын гишүүн, сэргээн засварлагч, доктор О.Ангарагсүрэн, Монгол улсын Үндэсний номын сангийн ном бүрдүүлэх, боловсруулах, солилцох хэлтсийн дарга Г.Гүнжинлхам, Соёлын яамны Номын сангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах шинжээч Б.Баяраа, Үндэсний номын сангийн Ерөнхий номын санч Т.Баярлах нар удирдан явуулав.

2.2. Аймгийн ИТХ-ын 10 дугаар тогтоолын дагуу 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө 1.6-д заасан Соёл, урлагийн байгууллагын хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн 2 арга хэмжээг хэрэгжүүлж тайланг хугацаанд хүргүүлэн ажиллаж байна. Эхний хагас жилээр хэрэгжилт 100% тай. Тухайлбал: Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”, Дархан-Уул аймгийг 2022 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд ХНО-ны нийт ажилтан, албан хаагчид монгол бичгээр нэр хаягаа зөв бичиж сурч “Миний нэрийн хуудас” монгол бичгийн үзэсгэлэн гаргасан.

2.3. Аймгийн Засаг Даргын Үйл ажиллагааны хөтөлбөр /2021-2024/-т тусгагдсан соёл, урлагийн салбарын үйл ажиллагаатай холбоотой 6 заалтын хэрэгжилтийг тайлагнаж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж Хангалттай үнэлгээ авсан. 2022 оны 12 дугаар сарын байдлаар энэ оны хүрэх түвшин 100%-тай биелэсэн байна. Тухайлбал:

- “Дарханы нэвтэрхий толь” ном бүтээх судалгааны ажлыг 80 хувьд хүргэх зорилт дэвшүүлсэн гүйцэтгэл 90 гаруй хувьтай. Дархан хотын уугуул иргэд болон тус хотын бүтээн хотын бүтээн байгуулалтад оролцож явсан 120 гаруй ахмадуудтай уулзаж 1000 гаруй гэрэл зураг, товч намтар, дурсамж судалгааны материал цуглуулсан.. Ерөнхий редактораар Я.Зэнээмэдэр (Ph.D.) проф. ажиллаж байна.
- Соёлын яамны санхүүжилтээр аймгийн Музей нь 29 уран бүтээлчийн намтар, 62 урлагийн бүтээлийн тайлбар, мэдээлэл болон гэрэл зургаас бүрдсэн сургалт сурталчилгааны “**Дархан Музейн Урлагийн бүтээлүүд**” номын эхийг бэлтгэж, хэвлүүллээ. Номын нээлтийг 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр хийв.
- “Цахим соёл” дүрс бичлэгийн студи байгуулах 2023 оны төсвийн төсөлд суулгуулахаар Соёл, урлагийн газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 136 тоот албан бичгийг Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргалд уламжиллаа.

2.4. “Оюунлаг Дарханчууд” дэд хөтөлбөр 2021-2024-т хөтөлбөрт тусгагдсан соёл, урлагийн салбарын үйл ажиллагаатай холбоотой 7 заалтыг хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 100 %-тай байна.

2.5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд МУЗГ-ын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэлээр өгсөн дараах үүргийн биелэлтийг ханган ажилласан. Үүнд:

- XIII.5.2. Төрийн болон орон нутгийн музейн харуул хамгаалалтын чиг үүргийг гүйцэтгэхэд мөрдөх аргачлал, зааварчилгааг хамтран баталж мөрдүүлэх, харуул хамгаалалтын ажилтны ур чадварыг дээшлүүлэх заалтыг хасуулах санал хүргүүлсэн. Учир нь: Аймгийн Музей нь харуул хамгаалалтын ажилтан байхгүй учир дохиолол, хамгаалалтын үйлчилгээг “Дархан секьюрити” ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажилладаг.
- XIII.5.4. Харьяалах нутаг дэвсгэр дэх соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэх хүрээнд Түүх, Соёлын Хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор 5 судар бичигт модон шогол хийлгэсэн.

- Орон нутгийн төсвийн 3.500.000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар 18 ширхэг уран баримлыг сэргээн засварлах ажил хийгдэж, үзмэрийн хадгалалт хамгаалалт сайжирсан. Хэрэгжилт 100%

2.6. Соёл, урлагийн ажилтны 29 дэх өдрийг Дархан-Уул аймгийн хэмжээнд 2022 оны 09 дүгээр сарын 08-наас 9 дүгээр сарын 10-ны өдрүүдэд “Хандлагаа өөрчилье -Хамтдаа бүтээцгээе” уриан дор “Соёлын орон зай” бий болгосон олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, тэмдэглэн өнгөрүүлээ. Тус үйл ажиллагаанд соёлын байгууллагуудаас гадна МСНЭ-ийн Дархан салбар, МЗЭ-ийн Дархан салбар зөвлөл, Зураач, урчуудын холбоо, Аялал жуулчлалын нэгдсэн холбоо, СӨБ, ЕБС-ийн Хөгжмийн багш нар, Бүжгийн холбоо, Гэрэл зурагчдын холбоо, Монгол II загварын агентлаг, Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх Хүүхэд хөгжлийн дугуйлангууд, Шонхоодой ардын цирк, Угалз уран нугаралтын төв, Чөлөөт уран бүтээлчид зэрэг нийт 260 гаруй уран бүтээлчид, ажилтан, албан хаагчид оролцсон.

2.7. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Төрийн албан хаагчдын мод тарих төгөлд Соёл, урлагийн салбарын 5 байгууллагын нийт 86 ажилтан нэгдэж модны мөнгө болох 2 418 922 төгрөг хандивласан.

2.8. Монгол Улсын Соёлын Сайдын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/300 тоот тушаалын хавсралт, маягтын дагуу Дархан-Уул аймгийн соёл, урлагийн салбарын харьяа 7 байгууллагын 2022 оны 12 сарын үйл ажиллагааны статистик мэдээг улирал тутам, тухай бүрт нь холбогдох дээд шатны байгууллагын мэргэжилтний заавар, зөвлөмжийн хүрээнд авч нэгтгэн ЗГХА- Соёл, урлагийн газарт хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа.

ГУРАВ. ТӨРӨӨС СОЁЛЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД:

3.1. Соёлын үнэт зүйлийг бэхжүүлэх /Алсын хараа 2050/, бүх нийтийн соёлын боловсрол соён гэгээрүүлэх ажлын хүрээнд;

➤ **Монгол хэл, бичгийн хүрээнд:** “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Соёлын тухай хууль, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”, “Оюунлаг Дарханчууд-2” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр олон талт ажил хийгдлээ.

- “Хос бичигтэн байгууллага” аянд соёл, урлагийн 7 байгууллагыг бүрэн хамруулсан.
- “Бийрээ нийлье” уран бичлэгийн уралдааныг зохион байгуулж, ерөнхий боловсролын 5 сургуулийн 29 сурагч, 3 багш оролцсон.

- **“Хамгийн сайхан хот”** монгол бичгийн үзэсгэлэнг зохион байгуулж нийт 600 хүн хамрагдлаа.
- **"Монгол бичиг - Монгол бахархал"** түргэн уншлагын уралдааныг ЕБС-ийн дунд ангийн сурагчдын дунд зохион байгуулж, 8 сургуулийн 88 сурагч оролцсон байна.
- **“Мөнх оршихуй-III”** бийрийн бичлэгийн уралдааныг зохион байгуулж, багш сурагчдын 42 бүтээлээр үзэсгэлэн гаргасан.
- **“Үндэсний бичиг манай хамт олны өв соёл”** цахим контент бүтээх уралдаанд төрийн 30 байгууллага оролцсон бөгөөд үүнээс соёл, урлагийн 2 байгууллагын /Төв номын сан, Хүүхдийн номын ордон/ 32 ажилтан оролцов. Аймгийн төв номын сангийн хамт олон Үндэсний бичгийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах, иргэд уншигчдыг үндэсний бичгээ сурах хүсэлд хөтлөх, урамшуулах олон ажлуудыг зохион байгуулсан дүнгээр 3 дугаар байр эзлэв.

➤ **Угийн бичиг хөтлөх, уламжлалыг сэргээх, дэмжих хүрээнд:** Алсын хараа 2050 Зорилт 2.7 Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжинэ, Соёлын тухай хуулийн 8 дугаар зүйл 8.4, 15 дугаар зүйл 15.2.2, Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоол, Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 61 дүгээр тогтоол, “Оюунлаг Дарханчууд-2” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор чиглэлээр олон талт үйл ажиллагааг зохион байгуулж байна.

➤ **Угийн бичиг хөтлөх** нийт 4 удаагийн сургалт зохион байгуулж 34 насанд хүрэгч, 198 хүүхдийг хамруулсан. Үүнд: **“Угийн бичгээ хөтөлцгөөе”** сургагч багш бэлтгэх сургалтыг 2022 оны 10 дугаар сарын 20, 21-нд зохион байгуулав. 2 удаагийн сургалтад 4 сумын төлөөлөл, соёлын байгууллагын ажилтнууд болон угийн бичиг бичиж сурах хүсэлтэй 23 иргэн хамрагдлаа. Төв номын сангаас Од цогцолбор сургуулийн 7 дугаар ангийн 12 сурагчид **“Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол”** сургалт явуулсан. Мөн Хонгор сумын 160 гаруй иргэнд **“Ургаа уудалъя”** сургалт хийсэн. **“Ургаа уудалъя”** угийн бичгийн үзэсгэлэнд Дархан сумын 18 багийн 14 ахмад угийн бичгийн ном товхимол, гар бичмэлээр оролцсон. Үзэсгэлэнд ирсэн угийн бичгүүдээс 3 угийн бичгийг шалгаруулж өв соёл, удам угсаагаа үр хойчдоо таниулж буйд талархан урамшууллаа. Үүнд: Дархан сумын 3 дугаар багийн иргэн Я.Энэбишийн гэр бүл нөхрийн талын “Өнө мөнхөд бадрах ургийн бичиг” 7 үе, эхнэрийн талын “Баян авгынхан удмын шастир” 9 үеэрээ гаргасан ном, Дархан сумын 7 дугаар багийн иргэн Д.Мягмар 9 үеийг оролцуулсан номонд 1800 гаруй удмынхан оролцсон угийн бичиг, 15 дугаар багийн иргэн Хуягбаатарын гэр бүлийн “Чандманийхны удам ургийн хэлхээ” угийн бичгүүд шалгарлаа.

➤ Хүүхдийн номын ордон нь **Угийн бичиг хэрхэн хөтлөх** талаар 3 цахим мэдээлэл бэлтгэн байршуулж 17899 хэрэглэгчдэд хүргэсэн.

➤ “Монгол хүний удмын сан, Угийн бичиг хөтлөх журам”-ыг хэрэгжүүлэх, сургагч багшаар ажиллах эрхийг номын сангийн ахлах номын санч Г.Нямцэнд, Ном зүйч Х.Отгонбаяр нар, Соёлын боловсролын үндэсний сургагч багшаар ажиллах батламжийг захирал Б.Цэцэгсүрэн нар авч нийгмийн, нийтийн соён гэгээрүүлэх ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж байна.

➤ Соёлын тухай хуулийн 16.2.3, 16.2.5, 18.1, 18.6, Номын сангийн тухай хуулийн 16.2.5, 23.1, 23.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 124 дүгээр зарлиг; (Үндэсний баялагт ном хандивлах тухай), Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу **Төв номын сангийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх чиглэлээр** идэвхтэй ажиллаж байна.

➤ 2022 оны 12 сарын байдлаар Улсын төсөв болон хандиваар 34,255,589 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар номын баяжилт хийж, сан хөмрөгийн тоо 3037 ботиор нэмэгдсэн. Үүнээс: Хандиваар 7,614,490 сая төгрөгийн 1211 нэр төрлийн 1318 боть, худалдаагаар 26,641,099 сая төгрөгийн 661 нэр төрлийн 1720 боть ном, 10 нэр төрлийн тогтмол хэвлэл, урьд оны үлдэгдэл 83 нэр төрлийн 125 боть ном, хэвлэлийн бүтээгдэхүүнээр фондоо баяжуулсан.

➤ 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар 72 945 боть номтой. Үүнээс 70704 нь цахим каталогт байршсан. Үүнд: Хүүхдийн Номын Ордны номын сангийн цахим каталогт <http://darkhan.monbiblio.com> 15,000 гаруй боть ном, Төв номын сангийн сан хөмрөг нь 57945 боть номтой, үүнээс 55704 номыг электрон каталогт <http://darkhan.lib4u.net> оруулсан.

➤ Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн цахим санд Найрамдлын Дархан сонины 1983, 1984, 1985, 1986, 1988 оны 426 дугаар 1737 хуудас 6922 талыг цахим сүлжээнд орууллаа. 12 дугаар сарын 02-ны байдлаар Уншигч 10,919, Ирэгсэд давтагдсан тоогоор 101,881, Ном олголт 131,006 боть номоор үйлчилсэн байна.

➤ 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар 823 уншигчдад 3,727 боть номыг гэрээр олгож үйлчилсэн. Нүүдэл, зөөврийн номын үйлчилгээг 23 удаа 1037 хүнд 1360 боть ном олгож үйлчиллээ. Номын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.3.5, Соёлын тухай хуулийн 18 дугаар зүйл 18.1.3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг (Номын баярын өдөр тэмдэглэх тухай)-ийг хэрэгжүүлэх хүрээнд “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд 2022”-ыг УИХ-ын дарга Г.Занданшатарын ивээл дор “Илүү их уншъя” уриатайгаар 2 удаа зохион байгууллаа.

➤ Тус өдрүүдэд нийт **70** удаагийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 26 байгууллага, 19605 хүн оролцсон. Тухайлбал: Төв номын сан, Музей, Залуучууд театр, Хүүхдийн номын ордон, бүх шатны боловсролын байгууллагууд, иргэд, уншигч олны дунд хүртээмжтэй байдлаар явуулж нийт 15 байгууллагын 130 гаруй ажилтан, СӨБ-ын байгууллагын 160 орчим хүүхэд, ЕБС-ийн 170 гаруй сурагч, их дээд сургуулийн 80 оюутан, 18 багийн ахмадын

зөвлөлийн 280 гаруй ахмадууд, “Номын соёлт ертөнц” ТББ-ын хамт олон, Улаанбаатар хотоос 50 зохиолчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг номын баярт оролцлоо. Энэ хүрээнд:

- Хэвлэлийн бага хурал 2
- Эрдэм шинжилгээний хурал 2 удаа 94 хүн
- Зохиолч, уншигчдын уулзалт 10 удаа 811 хүн
- Уншаад урагшлахуй
- Оюунлаг Дархан өдөрлөг 5 удаа 497 хүнд 437 боть ном
- Номын үзэсгэлэн 18 баг, 2 байгууллагад 610 боть ном
- Номын сангийн тухай хуулийн хэлэлцүүлэг 1 удаа 15 хүн
- Номын худалдаа 18 баг, 2 ААН
- Шинэ номын нээлт 4 удаа 191 хүнд
- Кофе ба цай уншлага 1 удаа 20
- Уран зохиолын дүрийн болон уншигчдын жагсаал 1 удаа 300 гаруй хүн
- Өв соёл, язгуур урлаг сурталчлах ажил 1 удаа 120 хүн
- Ургаа уудалъя угийн бичгийн үзэсгэлэн 1 удаа 60 гаруй хүн
- Уралдаан 6 удаа 250 хүн
- Лекц 9 сэдвээр 140 хүн
- Илтгэл 1
- Хямдралтай номын худалдаа
- “Кодоо бичиж сурцгаая” уриатай Код гэж юу болох, анимейшн бүтээх сургалтыг Непко” хэвлэлийн газраас зохион байгуулж 15 хүүхэд хамрагдаж анхан шатны мэдэгдэхүүнтэй боллоо.
 - “Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн”-ий болзол хангасан ЕБС-ийн 3 анги хамт олныг тодруулж шагнав.
 - “Шинэ номын үзэсгэлэн” 16 удаа 411 боть номоор, “Сэдэвчилсэн номын үзэсгэлэн”-г 52 удаа 3038 боть номоор 8309 хүнд хүрсэн.
 - “Номын цахим үзэсгэлэн”-г 6 удаа 135 боть номоор гаргасан. /Цахим үзэсгэлэнгийн хандалт- 3811/, Чанга уншлага 59 анги бүлгийн 2195 хүүхдэд хийсэн.
 - Соёлын яамнаас “Үндэсний бичиг үсгийн баяр 2022” хаврын баярыг “Үндэсний бичиг үсэг Монгол соёлын үнэт өв” уриан дор зохион байгуулж тус баяраар 21 аймгийн Нийтийн номын сангуудаас шилдэг номын санг шалгаруулж “**НОМ ЦОМ**”-ыг Дархан-Уул аймгийн Төв номын санд гардуулан өгөв.
 - Ард иргэдийг номтой нөхөрлүүлэх аяны хүрээнд “Үдшийн Уншлага”, “Зуны уншлага” -ыг “Найрамдал талбайд”, “Дархан-50” цогцолборт 7 удаа зохион байгуулж, шинээр 27 уншигч бүртгэж, 388 ирэгсдэд 378 боть номоор үйлчилсэн. “Номтой аялал”-ыг 5 удаа зохион байгуулж 176 сурагч хамрагдсан.

➤ “Соёлын орон зай” өдөрлөгийн хүрээнд “Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн”-ий болзол хангасан 3 сурагчийг шагнав. Дархан-Уул аймгийн зохиолчдын номын үзэсгэлэн, Шинэ номын үзэсгэлэн 183 боть номоор гаргаж, хуучин номын худалдаа хийв. “Угсаатны зүйн үзмэр”-үүд гэрэл зургийн үзэсгэлэнг зохион байгуулсан нийт 100 гаруй хүүхэд хамрагдсан.

➤ Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх хүрээнд “**Авъяаслаг төрийн албан хаагчид**” урлагийн наадмыг 2022 оны 11 дүгээр сарын 11, 12, 18, 19-ний өдрүүдэд Гоцлол, дуэт, хамтлаг дуу, гоцлол, хамтлаг бүжиг, гоцлол, хамтлаг хөгжим, язгуур урлаг, уран уншлага, жүжигчилсэн тоглолт зэрэг 10 төрлөөр зохион байгуулж нийт 25 байгууллага 12 багт хуваагдан амжилттай оролцсон. Төрөл тус бүрд эхний 3 байрыг шалгаруулж урамшуулсан. Шилдэг номеруудаар 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Гала тоглолт тоглоно.

➤ Соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд Дархан хот дахь “Оргил”, “Номин” худалдааны төвүүдэд очиж хөгжмийн бүтээлээр үйлчиллээ. Мөн хөдөөгийн 3 сумдад “Алтан намар “ аялан тоглолтыг амжилттай зохион байгуулж нийт 800 гаруй ард иргэдэд соёл урлагийн арга хэмжээгээр үйлчиллээ. Ахлах ангийн 150 гаруй сурагчдад урлагийн 4 төрлийн мэргэжил сурталчлав. Анагаах ухааны их сургуулийн оюутнуудад “Бидний бахархал” лекц, тоглолтыг зохион байгууллаа.

➤ “Хотын соёл биднээс эхэлнэ” аяныг зохион байгуулав. Нийт 1746 иргэдэд сурталчилсан.

➤ Хонгор сумын Соёлын төв, ЗДТГ хамтран хотын соёлыг төлөвшүүлэх хүрээнд “**Нөлөөллөөс дээгүүрт**” арга хэмжээг зохион байгуулсан. 170 залуус хамрагдсан.

➤ Сумдын соёлын төвийн үзвэр үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, иргэдийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх хүрээнд Орхон, Хонгор, Шарын гол сумын Соёлын төвүүдэд нийт 61 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулагдаж 11614 том хүн, 3374 хүүхдэд соёл, олон нийтийн үйл ажиллагааг хүргэсэн байна. Энэ нь нийт сумдын хүн амын 67%-д хүрч ажилласан байна.

➤ ММСАМХолбооноос “Darkhan Drift Series” тэмцээн зохион байгуулах санал тавьж аймгийн Засаг даргаас тус тэмцээнийг аймгийн баяр наадмын нээлт болгон зохион байгуулах үүргийг Соёл, урлагийн газарт өгсний дагуу тэмцээнийг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулав. Тэмцээнд Улаанбаатар, Дархан-Уул, Орхон аймгаас мэргэжлийн нийт 36 тамирчин оролцсон.

3.2. Соёлын өвийг хамгаалах чиглэлээр;

➤ “Иргэд, сүм хийдэд хадгалагдаж буй баримтат өвийг бүртгэлд хамруулах” ажлын хүрээнд Дархан сумын СББӨ-ийг өвлөн уламжлагч О.Туул, Хонгор сумын иргэн СББӨ-ийг өвлөн уламжлагч Д.Бовийшийрэв, Шарын гол сумын Гэлэгпэлжээлийн хийд, Дархан сумын иргэн, марк цуглуулагч Д.Сайнхүү нарт хадгалагдаж байсан нийт **45** ширхэг баримтат өвийг

бүртгэн баримтжууллаа. Уг бүртгэлд 1911-1925 оны үеийн засаг захиргаа, шүүх яамны холбогдолтой дүрэм, өргөх бичиг, тогтоол, Дотоод хэргийн яамны офицеруудын гэрэл зураг, Утга зохиол сонины анхны дугаар, Ламын гэгээний хийдийн маарамба Цэдэнбалжираас үе уламжлан ирсэн ном судар, модон бар, танка зураг, Д.Сүхбаатарын марк /1932 онд хэвлэгдсэн/, Атилла хааны марк /1952/, Чингис хааны марк /1962/ зэрэг баримтат өвүүдийг хамрууллаа.

➤ Хүүхдийн номын ордон нь Соёлын баримтат өв /ном хэвлэл/-ийг технологийн дагуу сэлбэн засварлах, сэлбэн засварлалтын картжуулалт хөтөлж баримтжуулах, технологийн дагуу ариутган халдваргүйжүүлэх хүрээнд сан хөмрөгийн номын 15,6%-ийг буюу 2029 сэлбэн засварлаж, нийт номын 77,8% буюу 10125 ном ариутгаж халдваргүйжүүлсэн.

➤ Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 47 дугаар зүйл. Соёлын өвийг сэргээн засварлах үйл ажиллагаа 47.1, 47.1.1, 47.1.2 зүйлийг үндэслэн Түүх, соёлын хөдлөх дурсгал болох уран баримал сэргээн засварлах ажлыг аймгийн Музей Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ажлын хүрээнд 3,500,000 төгрөгөөр хийж гүйцэтгэв. Нийт 18 баримлыг сэргээн засварласан.

➤ Соёлын өвийн тухай хуулийн 35 дугаар зүйл, Соёлын биет өвийг худалдах, худалдан авах 35.2 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Музейд 1961-1981 онд илгээлтээр Дархан хотод ирж ажиллаж амьдарч байсан айл өрхийн тухайн үеийн байдлыг харуулах зорилгоор "Илгээлтийн эзэд" булан төслийг Дархан сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 5,360,000 төгрөгөөр хийж гүйцэтгэв.

➤ Музейн үзмэрт байгаа мөнгөн тэмдэгтүүдийг иж бүрдэл ажлын хүрээнд сан хөмрөгөө баяжуулах хүрээнд Аймгийн Музейд орон нутгийн 3,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 14 монгол мөнгөн тэмдэгтийг иж бүрдэл болгон бүрдүүлсэн. Ингэснээр монгол мөнгөн тэмдэгтийг сурталчилан таниулах үзмэр баяжилт нэмэгдсэн.

➤ Үзвэрийн 4 танхимд нийт үзмэрийн тоо 969 дэсийн 1362 ширхэг үзмэртэй байсан бол 2022 онд 29 дэсийн 46 ширхэг үзмэрээр шинээр баяжуулж 998 дэсийн 1408 ширхэг болж нэмэгдсэн.

➤ Дархан-Уул аймагт **“Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого”**-ын ажлыг 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс эхэлж бүртгэн баримтжуулалт, судалгааны ажлыг 09 дүгээр сарын 28-нд дуусч www.rich.mongoluv.mn программд дурсгалуудыг шивсэнийг хянаж 100 хувийн гүйцэтгэлтэйгээр дуусгаж Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлж хянууллаа. Тооллогоор нийт 51 дэсийн 361 үзмэрийг 100% хамрууллаа. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн улсын тооллого зохион байгуулах ажилд ЗГХА- СУГ-аас **10.0** сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

➤ Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 42 дугаар зүйл, 42.2 заалтыг хэрэгжүүлэх зорилгоор тус аймгийн ИТХ-ын 8 дахь удаагийн бүрэн эрхийн ээлжит бус 13 дугаар

Хуралдаанаар /2022.11.23/ Хонгор сумын нутаг Говил уулын орчмын 20 га талбайг орон нутгийн хамгаалалтад авлаа. Уг дурсгалт газрыг Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхимийн Профессорын 2 дугаар багийн ахлагч, доктор Т.Идэрхангайгаар ахлуулсан судалгааны баг 2022 оны малтлагын ажлаар 11 бунхант булш, 3 жирийн иргэний булш, 1 тахилгын байгууламжийг илрүүлсэн юм. 2023 онд дээрх судалгааны баг 3 сарын хугацаатай дахин малтлага хийхээр төлөвлөгөө гаргаж уг ажлын төсвийг Дархан-Уул аймгийн Орон нутгийн төсвөөс 70 сая төгрөгөөр дэмжихээр аймгийн ИТХ-ын 8 дахь удаагийн бүрэн эрхийн ээлжит бус 14 дүгээр Хуралдаанаар /2022.12.03/ батлав.

➤ **Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгааг** зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 01-А/299 тоот Захирамж гарч судалгааны ажлыг 11 дүгээр сарын 02-ны өдөр эхлүүлээ. rich.mongoluv.mn программд тус аймгийн 74 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг бүртгэн баримтжуулсан байдаг. Дээрх судалгааны дүнд нийт 90 өвлөн уламжлагчийг бүртгэлд хамруулав. Соёлын биет бус өвийг уламжилсан байдал, шилжилт хөдөлгөөн, нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн нөхцөл байдлын дагуу судалгааны ажлыг явуулав.

➤ Дархан-Уул аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Захирамжаар **“Нүүдэлчин Монгол”** наадам зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж удирдамж, бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлав. 7 дугаар сарын 10-ний өдөр Дархан суманд “Нүүдэлчин Монгол” наадмын 1 дүгээр шалгаруулалтыг 7 ай саваар 100 гаруй иргэнийг оролцуулан зохион байгуулсан. Тус наадмаас 39 өвлөн уламжлагчийг 2 дугаар шатанд шалгаруулав. Улмаар **“Нүүдэлчин Монгол 2022” соёлын фестивальд** бага насны өвлөн уламжлагч 6 хүүхэд, Монгол Улсын Соёлын тэргүүний 9 ажилтан, зургаан Ардын авьяастан зэрэг нийт 61 хүний бүрэлдэхүүнтэй оролцсоноос:

- Соёлын бүтээлч үйлдвэрлэл төрөлд “Монгол бичиг QR код” бүтээлээр Б.Булганчимэг,
- Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд” төрөлд Ж.Эрхэмсайхан,
- Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл төрөлд Ц.Буянхишиг нар шалгарч **шилдэг өвлөн уламжлагч медаль** тус бүр 1.000.000 төгрөгөөр шагнуулсан.

Тус наадамд оролцоход аймгийн ЗДТГ-аас 5.0 сая, Дархан сумын ЗДТГ-аас 5.0 сая, Хонгор, Орхон, Шарын гол сумын ЗДТГ, Соёлын төвөөс тус бүр 3.0 сая нийт **19 сая** төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

➤ “Нүүдэлчин Монгол” соёлын фестивалийн Шилдэг өвлөн уламжлагчдын бүтээл болон **“Монгол хүний өв соёл”** сэдэвчилсэн номын үзэсгэлэнг дэлгэн толилууллаа.

➤ Дархан-Уул аймгийн Ахмадын дунд **“Өвлөн уламжлагчдын наадам”**-ыг 2022 оны 11 дүгээр сарын 10 - 30-ны хугацаанд Ахмадын хөгжлийн төв, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулав.

➤ Монголын Хүүхдийн Ардын Урлагийн Төв сантай хамтран **"Ардын аялгуу"** урлагийн их наадмыг СББӨ-ийн өвлөн уламжлагчдын дунд зохион байгууллаа. Тус наадамд гоцлол морин хуур хөгжмөөр Б.Дүйнхэрсүрэн, Хотгойд ардын уртын дуугаар Ш.Наранцэцэг нар Гран при шагналын эзэн боллоо. Шүүгчийн бүрэлдэхүүнээр МУАЖ Ө.Баярмагнай, СГЗ Ж.Эрдэнэтуяа, соёл судлаач, МУСТА Г.Нарангэрэл нар ажиллалаа.

3.3. Урлаг, уран бүтээл, уран бүтээлчдийг хөхиүлэн дэмжих чиглэлээр;

➤ Аймгийн хэмжээнд 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийт 104737 хүн амын 69.9% буюу давхардсан тоогоор 72373 насанд хүрэгчдэд, 1-19 насны нийт 38021 хүүхдийн 58,2 %-д буюу давхардсан тоогоор 22134 хүүхдэд театр, урлагийн уран бүтээлээр үйлчилсэн байна. Нийт үзэгчид давхардсан тоогоор 96095 байна.

➤ Гадна, дотны тоглолтыг дэмжин ажиллах, соёл урлагийг түгээн дэлгэрүүлэх хүрээнд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 292 удаагийн гадна, дотны тоглолт, арга хэмжээ зохион байгуулагдсан байна.

➤ Залуучууд театр нь тайлант онд дотоодын 21 уран бүтээлийг 103 удаа тоглож 36386 хүнд үзүүлсэн. Үүнд:

- **"Домог амилсан нутаг"** дуулалт жүжгийг нийт **18** удаа тоглож, 5860 хүнд үйлчилсэн. Нийт орон нутгийн төсөвт 23 сая төгрөг төвлөрүүлсэн. Тус уран бүтээлээр Гэгээн муза 16 Олон Улсын театрын наадамд нэр дэвшин оролцсон.
- **"Лануш"** хүүхдийн жүжиг 16 удаа тоглож, 3830 хүүхдэд үйлчилсэн. 16 сая төгрөгийн орлого төвлөрүүлэв.
- **"Хараацай хэдгэнэ хоёр"** хүүхэлдэйн жүжиг 2 удаа үнэ төлбөргүй тоглогдож 800 хүүхдэд үзсэн.
- Америкийн жүжгийн зохиолч, утга зохиолын Нобелийн шагналт Южин Гладстон О'Нил -ийн зохиол, **"Өглөөний цайны өмнө"** моно жүжгийг 2 удаа тоглож 600 хүнд үйлчилсэн. Тус жүжгээр Гэгээн муза 16 олон улсын театрын наадмын нэг хүний жүжгийн төрөлд нэр дэвшин өрсөлдсөн.
- **"Сэтгэлийн эгшиг", "Хайртай"** 2 хандивын тоглолт 4 удаа тоглож, 2000 хүнд үйлчилсэн.
- Лилия Сафикановагийн зохиол, Залуучууд театрын Ерөнхий найруулагч М.Цогтын найруулсан **"Хайрт минь энэ ердөө л эхлэл"** моно жүжгийг 3 удаа тоглож, 600 хүнд үйлчилсэн. Тус жүжгээр "Гэгээн муза" 15 дахь удаагийн олон улсын театрын наадамд оролцож шилдэг залуу уран бүтээлчээр Залуучууд театрын жүжигчин Ч.Дунгаамаа шалгарч байсан юм.
- Хүний наймааны золиос болсон хоёр бүсгүйн тухай өгүүлэх **"Өглөөний нар"** 2 хүний жүжгийг анх удаа туурвиж 2 удаа тоглож, 780 хүнд үйлчилсэн. Жүжгийн зохиолчоор Л.Билгээ, найруулагчаар Б.Баттуяа, ажилласан.

- **“Би эх орны хүү”** цэргийн хүрээний байгууллагуудтай хамтарсан тоглолтоор 500 гаруй хүнд үйлчилсэн. 1.600.0 мян төгрөгийн орлого төвлөрүүлэв.
- Залуучууд театрын хөгжмийн зохиолч О.Золбаярын тайлан тоглолт 3 удаа тоглогдож, 1500 хүнд үйлчилсэн. Тус уран бүтээлийн тоглолтоор **“Нар наадсан монгол өргөө”**, **“Адуучин залуус”** 2 уран бүтээлийг шинээр хийж урын сангаа баяжуулсан.
- Залуучууд театрын “Гүрэн” хамтлагийн **“Язгуур Монгол”** тайлан тоглолтыг 2 удаа тоглогдож 820 ард иргэдэд соёлын биет бус өв, язгуур соёлыг хүргэсэн.
- **“Мэндийн цэнхэр хадаг”** ардын зан заншил, язгуур урлагийн концертыг нэг удаа тоглож 588 үзэгч үзсэн. УГЗ Сэр-Од хөгжим, СГЗ шүлэг **“Эх орон эзэн Заяа”** дууг дуучид дуулж, бүжигчид бүжиглэн МҮОНТ-д бичүүлж, үзэгчдийн хүртээл болгосон.
- **“Жаргалтай жарны дуулал”** хүндэтгэлийн концертыг Ерөнхий найруулагч МУСТА, М.Цогт шинээр найруулан нийт 5 удаа тоглож 3000 иргэдэд үнэ төлбөргүй толилууллаа.
- Дархан хотын 60, 61 жилийн ойн баяр наадмын **“НЭЭЛТ, ХААЛТ”**-ын тоглолтыг Залуучууд театрын Уран сайхны удирдагч МУСТА Г.Саранчимэг шинээр найруулан толилуулсан. Аймгийн баяр наадмаар нийт 1000 гаруй үзэгчдэд хүргэсэн.
- **“Шидэт модны үр”** хүүхдийн жүжгийг Залуучууд театрын жүжигчин Л.Хишигсүрэн шинээр найруулж 30 удаа 9419 хүүхэд багачуудад хүргэсэн. Тус уран бүтээлийг орон нутгийн төсвөөс 37.893.800 төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр дэмжсэн.
- Залуучууд театрын дуучин Л.Эрдэнтулгын **“Нас тогтох сайхан”** тоглолт 1 удаа тоглож 500 иргэдэд үйлчиллээ.
- Залуучууд театрын дуучин Б.Бат-Эрдэнийн **“Хүндэтгэл”** тоглолт 1 удаа тоглогдож 500 ард иргэдэд үйлчиллээ.
- Залуучууд театрын хөгжимчин, МУСТА Т.Ган-Эрдэнийн **“Тэнгэрт тогтсон уулс минь”** концерт 1 удаа тоглогдож 400 гаруй хүнд үйлчилсэн. Тус тоглолтод Залуучууд театрын дуу, бүжиг, хөгжим ангийн 50 гаруй уран бүтээлчид оролцов.
- Монгол Улсын гавьяат жүжигчин Д.Дагийсүрэнгийн **“Сонгодог үдэш”** тоглолт болов. Тус тоглолтыг 450 гаруй иргэд үзлээ.
- Залуучууд театрын Өвөл цагийн үзвэрийн 46 дахь удаагийн нээлт, Лев. Корсунскийн зохиол, найруулагч МУСТА М.Цогтын бүтээл **“Нэр зээлдэгч”** драмын жүжиг 7 удаа тоглогдож 2239 үзэгчдэд хүргэсэн.
- Залуучууд театрын дэргэдэх Дионис агентлаг **“Үлгэрийн Ертөнц 2”** кино контентыг найруулан 1 удаа 400 хүүхэд багачуудад толилуулав. Найруулагчаар Залуучууд театрын жүжигчин, Дионис агентлагийн багш Л.Хишигсүрэн ажиллав.
- Залуучууд театрын 12 уран бүтээлч бүсгүйн **“Аясгалан-12”** тоглолт 1 удаа тоглогдож 600 ард иргэдэд үйлчиллээ.

3.4. Соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр;

➤ Соёлын бүтээлч сарын туршид буюу 2022 оны 11 дүгээр сарын 01-30-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд 134 ажлыг зохион байгуулж 69050 хүнд соёл, урлагаар үйлчилсэн.

➤ Соёлын яамнаас зохион байгуулсан **"Соёлын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, уламжлалт гар урлалыг дэмжин хөгжүүлэх боломж шийдэл - 2022** нэгдсэн арга хэмжээнд 1000 гаруй урлаачдын 2000 бүтээл оролцоноос Дархан-Уул аймгийн оролцогч "Цайны их зам" ХХК-ийн үйлдвэрлэдэг ширэн эмээлүүд "Шилдгийн шилдэг" бүтээгдэхүүнээр шалгарлаа.

➤ Аймгийн Төв номын сангаас **"Монгол бахархал"** хөөрөг, даалин урлаач, уран дархчууд, уран хатгамалчдын сургалт, үзэсгэлэн худалдааг зохион байгуулж 100 гаруй иргэд хамрагдсан.

➤ Дарханы Зураач, урчуудын эвлэлээс 28 уран бүтээлчийн 54 бүтээлээр **"Шинэ салхи"** уран бүтээлийн үзэсгэлэнг Дархан, Орхон суманд 7 хоногийн турш толилуулж 500 гаруй хүн үзэж сонирхсон.

➤ МУСТА, уран дархан Д.Түмэнжаргал, Н.Мөнгөнбаяр, С.Мөнхбаатар нарын 40 орчим орчин цагийн соёлын өвийн бүтээлүүдээр түр үзэсгэлэн гаргасан. Мөн үеэр МУСТА, уран дархан Д.Түмэнжаргал **"Уран дарханы түүхэн хөгжил"** сэдвээр ярилцлага хийлээ. Нэг өдөр дэлгэсэн түр үзэсгэлэнг 58 хүүхэд, 28 насанд хүрэгч нийт 86 хүн үзэж сонирхлоо.

➤ Шарын гол сумын соёлын төвөөс Шарын голчууддаа эко даавуун тор хэрэглэхийг уриалан **"Нутгийн брэнд тор"**-ыг худалдаанд гаргалаа. Мөн бүтээлч үйлдвэрлэгчдээ дэмжиж цахим контент бэлтгэн 37462 хүнд сурталчилав. Үүнд:

- Хусны нүүрс үйлдвэрлэгч "Домогт Шарын гол" ХХК
- Дээл урлалын "Өлзий хээ" оёдол эрхлэгчид
- Эсгий гар урлалын үйлдвэрлэл явуулдаг иргэд
- Гэрийн нөхцөлд уламжлалт аргаар хэрчсэн гурил үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг танилцуулав.

➤ Хонгор сумын Соёлын төвөөс 2022 оны 11 дүгээр сард **"Бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаа"**-г сумын ЗДТГ-тай хамтран зохион байгууллаа. Нийт 150 орчим иргэн үйлчлүүлсэн.

3.5. Цахим бодлогын хэрэгжилтийн хүрээнд;

➤ Соёл, урлагийн газрын дарга болон харьяа соёлын байгууллагын удирдлагууд, албан хаагчдад тус бүрд нь албаны мэйл нээсэн. Хэрэгжилтийн тайланг Соёлын яаманд 2022 оны 10 дугаар сарын 25-нд цахимаар хүргүүлсэн.

➤ ERP системд Газрын болон харьяа соёлын байгууллагуудын дарга, албан хаагчид бүртгүүлж тус системийг ашиглаж хэвшсэн. Мөн аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын

нэгдсэн дотоод удирдлагын цогц систем /эйбл/-д Газрын дарга, албан хаагчдыг бүртгэж цаг үеийн мэдээ мэдээллийг авч тус программыг ашиглан хэвшиж байна.

➤ Хүний нөөцийн бүртгэл мэдээллийн шинэчлэгдсэн цахим системд /ХНУМТ/ соёлын байгууллагууд ажилтан, албан хаагчдын дэлгэрэнгүй мэдээллийг оруулж бүргэлжүүлээ

➤ Цахим гарын үсэг хэрэглэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу Соёл, урлагийн газрын албан хаагчид тоон гарын үсэг авсан.

➤ Соёлын байгууллагуудын нэгдсэн портал сайтыг ашиглалтад оруулж буйтай холбогдуулан тус газрын цахим хуудас болох <http://da.moc.gov.mn/> -ны ангилал, цэс үүсгэж мэдээлэл оруулах ажлыг сургалтад хамрагдсаны дагуу хийж гүйцэтгэж байна. Тухайлбал: Мэдээ мэдээлэл цэсэд нийт 44 мэдээлэл нийтэлсэн. Мөн Уран бүтээл-1500, Үзвэр үйлчилгээ-189, Соёлын биет бус өв-969, Баримтат өв-45 гэх зэрэг танилцуулга мэдээллүүдийг нийтэлсэн.

➤ Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар нэртэй <https://www.facebook.com/darkhan.gov/> пэйж хуудсыг хөтлөн ажиллуулж, тус газрын болон соёлын байгууллагуудын үйл ажиллагааг нээлттэй мэдээлж иргэд олон нийтэд сурталчилж байна. Тус цахим хуудсыг 2022.12.01-ний өдрийн байдлаар 23000 хүн дагаж, 19000 хүнд таалагдсан байна.

➤ Соёл, урлагийн газар нь “Цахим Дархан” төслийн хүрээнд нэвтрүүлсэн **ersdel-darkhan** <https://ersdel.e-darkhan.mn/>, **e-darkhan** <https://e-darkhan.mn/>, **иргэдийн индэр** цахим системүүдийг ашиглаж байна. 2022 оны 10 дугаар сарын 23, 24, 11 дүгээр сарын 01, 02-ны өдрүүдэд Соёл, урлагийн газрын болон харьяа соёлын 7 байгууллагын пэйж хуудас, Дарханы соёлынхон группт байршуулж иргэд, олон нийт, соёлын ажилтнуудад сурталчилсан. Аймгийн Мэдээлэл технологийн албанаас цахим системд нэвтрэх и-мэйл, нууц үгийг авч соёлын байгууллагуудад хүргүүлсэн. Тус системүүдээр дамжуулан Дархан-Уул аймгийн иргэдэд Төрийн байгууллагийн мэдээллийг хүргэх болон өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч байна. Одоогоор тус цахим системүүдэд иргэдээс соёлын чиглэлээр ирсэн санал, гомдол байхгүй байна.

➤ “Цахим соёл” үйлчилгээг түгээн дэлгэрүүлж, дүрс бичлэгийн студи байгуулна гэсэн арга хэмжээний хүрээнд Залуучууд театрт дуу дүрс бичлэгийн студид цахим концерт, шинэ уран бүтээлүүдийн ТВ шторк, контентыг бэлтгэн цахимаар сурталчлан ажиллаж байна.

➤ “**Цахим Музей**”-н хүрээнд СББӨ-ийг өвлөн уламжлагчдыг алдаршуулах, сурталчлах зорилгоор 18 удаагийн видео, шторк бэлтгэн цахимаар сурталчилав.

➤ Аймгийн номын сан нь Сонсох ном, PDF унших ном, шүлэг, яруу найраг, ЕБС, СӨБ болон дэлхийн сонгодог аяз, богино өгүүллэг зэрэг 296 боть **цахим номоор фондоо** баяжуулав.

3.6. Хүний эрх, хүүхдийн эрх хамгаалал, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн чиглэлээр болон хүчирхийлэл, гэмт хэрэг, садар самууныг сурталчилсан соёлын үйл ажиллагааг хориглох, урьдчилан сэргийлэх талаар холбогдох хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан талаар;

➤ Дархан-Уул аймаг нь 2022 оныг Хүүхэд хамгааллын жил болгон зарласан.

➤ 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/13 дугаар “Эцэг эхийн зөвлөл байгуулах тухай” тушаалыг Соёл, урлагийн газрын даргаар батлуулсан. Мөн Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоол, “Эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллах зөвлөмж”-ийн дагуу Соёлын байгууллагууд тус бүр “Эцэг эхийн зөвлөл” байгуулж хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийг хамгаалах талаар холбогдох хууль, тогтоомжуудыг судлаж “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

➤ 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Хүүхдэд ээлтэй Монгол” хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн чуулганаас гарсан уриалгын дагуу Дархан-Уул аймгийн соёл, урлагийн байгууллагууд хөшиг нээгдэх бүрд болон аливаа үйл ажиллагаа бүрийн эхэнд **“Хүүхдээ сонсоё - Хүлээцтэй байцгаая”** уриалгыг хэлж хэвшсэн. Дээрх уриалга дор соёлын байгууллагууд өөр өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан уриаг дэвшүүлэн ажиллаж байна.

- Хүүхдийн номын ордон нь “Ирээдүйн уншигчдыг хөтөлнө”
- Залуучууд театр нь “Бид соёлыг түгээж ирээдүйн соёлтой үзэгчийг бэлтгэнэ”
- Төв номын сан нь “Оюунлаг хүүхдийн төлөө”
- Аймгийн Музей нь “Хайрлагдсан хүүхэд хамгаалагддаг” уриаг дэвшүүлсэн.

➤ Соёл, урлагийн үзвэр үйлчилгээний худалдаалагдсан тасалбарын 1%-ийг хүүхдийн хөгжил, хамгаалалд зарцуулах тухай албан бичгийг соёлын байгууллагуудад хүргүүлсэн. Байгууллагууд албан хаагчдын хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах болон “Хүүхдээ сонсоё” арга хэмжээг зохион байгууллаа.

➤ “Хүүхэд хамгааллын бодлого”-ын хүрээнд дараах онцлог ажлуудыг зохион байгуулсныг нэгтгэн 2022 оны 10 дугаар сарын 25-нд ЗГХА Соёл, урлагийн газарт хүргүүлэв.

1. Хүүхдийн соёлын орчны таатай орчин, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр:

Аймгийн Хүүхдийн номын ордон нь 2022 онд өөрийн орлогыг хүүхэд, багачуудын сурч боловсрох таатай орчин бүрдүүлэх, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор дулааны тоолуур, сантехникийн шугам хоолойг шинэчлэх, шинэ танхимын засвар үйлчилгээ, тоног төхөөрөмж техник хэрэгслээр хангах, суудлын тоог нэмэгдүүлэх, үйлчилгээний цагийг уртасгах зэрэгт 6,500 000 төгрөгийг зарцуулсан.

Залуучууд театр нь “Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг”-ийг байгууллагын нийт албан хаагчид болон бусад хүмүүст харагдахуйц газар байрлуулан сурталчлан ажиллаж байна. Хүүхэд багачуудын үзвэрийн таатай орчин бүрдүүлэх зорилгоор их танхимын дулааны

шугам хоолойг засварлаж, 1 давхрын фоен, үзвэрийн их танхим, дугуй танхимд гэрэлтүүлгийг нэмэгдүүлсэн. Залуучууд театраар үйлчлүүлж буй иргэдэд зориулан авто зогсоолын талбайг чөлөөлж, нийтийн ариун цэврийн өрөөг үйлчлүүлэгчдэд хүртээмжтэй байдлаар хэвийн ажиллуулж байна.

2022.03.15-наас 06.10-ны өдрийг хүртэл ЕБС-ийн сурагчдыг өдрийн 3 ээлжээр театрын автобусаар зөөж үйлчилсэн.

Аймгийн төв номын сан нь уншигч хүүхдүүдэд ая тухтай орчин бүрдүүлэх зорилгоор салбар номын сангийн байрны, сантехникийн засвар үйлчилгээг хийв. Ном хэвлэлийг чөлөөтэй сурталчлах, шинэ номын мэдээ мэдээллийг шуурхай хүргэх, хэвлэн сурталчлах зорилгоор үзэсгэлэнгийн тавиурыг байршуулав.

Аймгийн музей нь “Ахуйн хүрээн дэхь осол гэмтэл, тэдгээрийн үед авах арга хэмжээ” эрүүл мэндийн сургалтыг 31 дүгээр цэцэрлэгийн эмч П.Алтанзултай хамтран зохион байгууллаа. Уг сургалтад Музейн ажилтан албан хаагчдийн 11 хүүхдүүд хамрагдсан бөгөөд гэмтэл осол болох үед авах арга хэмжээг биечлэн туршилт хийв. Мөн сургалтад хамрагдсан хүүхдүүдийнхээ дархлааг дэмжин витаминжуулалт зэргийг худалдан авч 70.000 төгрөгийг байгууллагын төсвөөс зарцуулав.

2. Соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгчдүүлэх чиглэлээр:

Аймгийн Соёл, урлагийн газраас соёлын ажилтны өдрөөр Соёл, урлагийн салбарын ажилтнуудын 300 хүүхдэд Соёл амралтын хүрээлэн дэхь хөдөлгөөнт 4 тоглоомон дээр үнэ төлбөргүй тоглох эрхийн бичиг олгосон. Мөн соёлын ажилтны өдрөөр төрөх тасагт шинээр мэндэлсэн нийт 34 эх, хүүхдэд хүндэтгэл үзүүлж бэлэг өгсөн. Эх үрсийн баярын тоглолтод оролцсон 60 хүүхдэд болон аймгийн баяр наадмын нээлтийн тоглолтод оролцсон 58 хүүхдэд бэлэг өгөв.

Бага, дунд, өсвөр насны хүүхэд, залууст зориулсан “**Open mic**” арга хэмжээг таслахгүйгээр үргэлжлүүлэх тухай аймгийн Засаг даргаас өгсөн чиглэлийн дагуу тус арга хэмжээг “Дархан-50 цогцолбор”, Хүүхэд хөгжлийн ордон, Хуримын ордны гадна талбай зэрэг газруудад нийт 25 удаа зохион байгуулж 750 гаруй хүүхдийг оролцуулсан.

2022 онд Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн шагналаар ЕБС-ийн 11 анги хамт олон, 18 сурагчийг шагнав.

Соёл, урлагийн газар, БШУГ хамтран **Хүүхдийн гар урлалын бүтээлийн үзэсгэлэн** зохион байгуулав. /300 хүн хамрагдсан/

Жаран нэгэн сурагчийн бийрийн бичвэрийн үзүүлэх тоглолтыг зохион байгуулж Дархан хотын сүлд дуу “Хамгийн сайхан хот”-ын үгийг өөр өөрийн өнгө аясаар сэтгэмжлэн бичүүллээ. Мөн үеэр багш, сурагчдад бийрэн бичлэгийн хэрэглэгдэхүүн хүлээлгэн өгөв.

СУГ, Монгол II загварын агентлаг хамтран **“Super fashion-2022”** төвийн бүсийн Шилдэг шинэ залуу модел, Шилдэг фото модел шалгаруулах 3 дахь удаагийн уралдааныг 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулав. II шатанд шилдэг 55 хүүхэд оролцов.

Аймгийн Хүүхдийн номын ордон нь уншигч хүүхдүүдийн эрэлт хэрэгцээ шаардлагыг үндэслэн шинээр “Чөлөөт уншлагын танхим”-ыг засч тохижуулан суудлын тоог 20-иор нэмэгдүүлэн анги нийтээрээ болон хэсэг бүлэг, найз нөхөд, баг хамт олноороо номын сангийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэн ажилласнаар уншигчдын тоо 10%-иар өссөн.

Тайлант онд 15.834.839 төгрөгийн 411 нэрийн 1074 боть номоор сан хөмрөгөө баяжуулсан.

Залуучууд театр нь “Энэрэл” цогцолбор сургуулийн сурагчдад “Лануш” хүүхдийн жүжгийг 1 удаа үнэ төлбөргүй тоглож хүүхдийн хөгжилд 1.400.000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. “Шидэт модны үр” хүүхдийн жүжгийн нээлтэд зориулж 2022.09.19-ний өдөр 150 ширхэг урилгыг зорилтот бүлгийн хүүхдүүдэд бэлэг болгон барилаа. **“Хараацай хэдгэнэ хоёр”** хүүхэлдэйн жүжиг 6 дугаар сарын 1-нд 2 удаа үнэ төлбөргүй тоглогдож 800 хүүхдэд үзсэн. Дархан хотынхоо түүхт ёс уламжлал, төрөлх хотоороо бахархах сэдлийг хүүхэд, багачууд, оюутан, залууст өгөх, соён гэгээрүүлэх зорилгоор “Домог амилсан нутаг” дуулалт жүжгийг ЕБС-ийн 5860 сурагчдад 18 удаа толилууллаа.

Аймгийн Төв номын сан нь үйлчилгээний хүртээмж, олон нийттэй харилцах ажлыг нэмэгдүүлэх чиглэлээр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран Цахим ном төслийг хэрэгжүүлж Unitel hub танхимын тоног төхөөрөмжүүдэд 320 гаруй номыг цахимаар байршуулж, уншигчдад хүргэж байна.

Хүүхдэд зориулсан ном хэвлэлээр фонд бүрдүүлэлтийн хүрээнд нийт ном 359 ширхэг, 4 855 000 төгрөгийн ном худалдан авсан. Үүнээс 26 боть 555000 төгрөгийн номыг хандиваар, 333 боть 4300 000 төгрөгийн номыг худалдаагаар авч номын фондоо бүрдүүлсэн.

Аймгийн Музей нь сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуультай хамтран хүүхдүүдийг Музей үнэгүй үзүүлэх, олон талт боловсролын хөтөлбөрт хамруулах зэрэг ажлыг тогтмол гүйцэтгэдэг. Одоогийн байдлаар “Оюуны Ирээдүй” цогцолбор, нэгдүгээр сургууль, есдүгээр сургууль, “Монгол оюу” сургууль, 3, 4, 5, 7, 12, 15 зэрэг цэцэрлэгүүд хамрагдаад байна.

3. “Тэгш оролцоотой хүүхэд хөгждөг, хөгжсөн хүүхэд хамгаалагддаг” зарчмын хүрээнд:

Аймгийн Хүүхдийн номын ордон нь номын сангийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд 4737 уншигч шинээр бүртгэгдэж, 31451 ирэгсдэд, 34080 ном, хэвлэлээр үйлчилсэн. Тус ордонд 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар Дархан суманд сурч байгаа ЕБС-ийн нийт /24143/ суралцагсдын 22.9% нь буюу 5550 хүүхэд, СӨББ-ын /9795/ суралцагсдын 0.24% нь буюу 24 хүүхэд номын сангийн уншлага үйлчилгээнд хамрагдсан байна.

Гэрээр 477 уншигчид 2963 боть ном олгож үйлчилсэн байна. Зөөврөөр 2 цэцэрлэг, 8 сургуульд 41 удаа, 1405 хүүхдэд 1765 боть ном хүргэж үйлчилсэн. “Номын богц” аянаар Нүүдлийн номын сангийн үйлчилгээгээр 8 удаа, 2782 ирэгсдэд, 8976 боть номоор үйлчилсэн. Ном хэвлэлийг олон нийтэд сурталчлах, ном унших арга барилд төлөвшүүлэх, Соёл Олон Нийтийн ажлыг нийт 11 арга хэмжээний хүрээнд 19 үйл ажиллагааг зохион байгуулж, 3646 хүүхдийг хамруулсан.

Мөн ЕБС-ийн сурагчдын хичээлээс гадуурх чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, номтой нөхөрлүүлэх, танилцуулах, бие даан сурч боловсроход нь дэмжин туслах, мэдээ мэдээллээр хангах, зөвлөн туслах, хоцрогдол арилгах, ЭЕШ болон бусад уралдаан тэмцээнд оролцоход бэлтгэх зорилгоор Англи хэл, Байгалийн ухаан, Монгол хэл-бичиг, Цахим ном-мэдээлэл, чөлөөт уншлага үйлчилгээний “BOOK & COFFEE танхимууд ажиллаж байна. 2022 онд төрөлжсөн танхимуудад нийт 2059 уншигч бүртгэгдэж, 13244 ирэгсдэд 14319 лавлагаа мэдээлэл өгч, ном хэвлэлээр үйлчилсэн байна.

Залуучууд театр нь байгууллагын нийт албан хаагчдын хүүхдүүдийн дунд “Талархал” захидлын уралдаан, “Гоцлон бүжиглэхүй” бүжгийн уралдаан, эцэг, эхчүүдийн дунд “АХА” тэмцээнийг тус тус зохион байгууллаа. Соёлын тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Дууны-2, Драммын-1, Хөгжмийн-4, Бүжгийн-1 нийт 8 дугуйлантай гэрээ хийн хамтран ажиллаж байна.

Залуучууд театрын Bellcanto дууны дугуйлангийн сурагч Х.Отгонзаяа, Б.Бямба-Эрдэнэ нарын хамтарсан “Эгшиглэнт хавар” тоглолтыг дэмжин хамтран зохион байгууллаа.

Аймгийн Төв номын сан нь Монгол бичиг үсэг, өв соёлоо сурталчилсан төрөлжсөн уралдаан тэмцээн, эрдэм шинжилгээний хурал, уулзалт, ярилцлага, соёл, уламжлалыг харуулсан цуврал үзэсгэлэнгүүд зэргийг бүх шатны сургууль, бусад байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Үүнд:

- “Бийрээ нийлье” уралдаанд шагналт байр 3, тусгай байр 3-ыг шалгаруулсан.
- Номын үзэсгэлэнг 7 удаа 457 боть номоор зохион байгуулав.
- Нүүдэл зөөврийн номын сангаар 6 удаа 630 хүүхдэд 720 боть ном олгож үйлчиллээ.
- **Урилгат уншлага** нийт 20 удаа 658 сурагч
- **Номын сантай танилцах аялал** нийт 17 сургуулийн 574 сурагчдад
- **Уншаад урагшлахуй - Оюунлаг Дархан** өдөрлөг 5 удаа 497 хүнд 437 боть ном
- Уран зохиолын дүрийн болон уншигчдын жагсаал 1 удаа 120 гаруй хүүхэд
- Уралдаан 6 удаа 250 хүн оролцсон.
- **“Үлгэрээс үлгэрлэе”** 4 удаа 250 гаруй хүүхэд багачууд оролцов.
- **“Чанга уншлага”** 10 удаа 447 бяцхан хүүхэд багачуудад
- **Зуны уншлага** нийт 4 удаа 195 хүнд хийв.

- **“Бид эх орны ирээдүй”** хөтөлбөрийн хүрээнд эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулж эхний 10 байранд орсон сурагчдыг шагнав. ЕБС-ийн 70 гаруй багш, сурагчид оролцов.

Аймгийн музей нь Дэлхийн гэр бүлийн өдөр Музейн 8 албан хаагчийн 14 хүүхдийг гэр бүлийн хамт “Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэн, Хүүхдийн галт тэргээр аялуулж “Тэшүүртэй бамбарууш” тоглоомын төвд тоглуулав. Мөн үеэр хүүхдүүдийн дунд 100м гүйлтийн тэмцээн зохион байгуулав. Аймгийн БТСГ-ын дэргэдэх Эцэг Эхийн Зөвлөлтэй хамтран тус байгууллагын албан хаагчдын 25 хүүхдэд **“Дархан-Миний хот”** Дархан хотын түүх, соёлын дурсгалтай танилцах аялалыг зохион байгуулав.

“Музейн макет бүтээх уралдаан” зарлаж шилдэг бүтээлийг шалгаруулж 300.000 төгрөгөөр шагнав.

Хэлний Бодлогын Үндэсний Салбар Зөвлөлийн Дархан салбартай хамтран **“Мөнх оршихуй-III”** бийрийн бичлэгийн уралдааныг зохион байгуулж багш, сурагчдын 42 бүтээлээр үзэсгэлэн гаргав.

“Хөгжлийн Бэрхшээлтэй Эцэг Эхчүүдийн Холбоо”-той хамтран 7 гэр бүлийн хүүхдүүдэд “Мандала” боловсролын хөтөлбөр, ээж нарт нь СББӨ-ийг өвлөн уламжлагч С.Одонцоо бий биелгээ зааж, өв соёлоо түгээв.

Сумдын соёлын төвүүд Нэгдүгээрт хүүхэд уриан дор олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлж хүүхэд багачуудаа баярлуулсан. Сумын “Алтан намар” өдөрлөгөөр хүүхдийн хөгжих, хамгаалуулах эрхийг ханган ажиллах зорилгоор боловсролын байгууллагуудад хичээллэх дугуйлан секцийг танилцуулах зэргээр хүүхдэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулж байна.

4. **Үндэсний өв соёл шингэсэн цахим контентуудыг бүтээхэд бодлогоор дэмжих арга хэмжээний хүрээнд:**

Аймгийн Хүүхдийн номын ордон нь Монгол Улсын Засгийн газраас баталсан соёл, урлагийн үйл ажиллагаатай холбогдолтой төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Шинэ номын мэдээллийг 16 удаа нийт 411 нэрийн номоор бэлтгэн ном зүйн бичилт хийж 16 цувралаар хэвлэн уншигчдад гарын авлага болгон гаргасан. Мөн цахим хэлбэрээр нийтэлж 21789 гаруй хэрэглэгчдэд хүргэсэн.
- Засгийн газрын 2019 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан “Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, Соёлын биет бус өвийн талаар хүүхэд багачуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор Цагаан сар, Эх хэл аман яруу найраг, Аялгуут аман яруу найраг, Аялгуут бус аман зохиол, Хүүрнэн өгүүлэх аман зохиол, Монгол уран бичлэг, Монгол уламжлалт номын урлал зэрэг мэдээлэл бэлтгэж,

өөрийн байгууллагын цахим хуудсандаа /[https://www.facebook.com /Nomiin.ordon/](https://www.facebook.com/Nomiin.ordon/) байршуулсан.

Залуучууд театр нь “Үлгэрийн Ертөнц 2” кино контентыг найруулан 12 удаа тоглож хүүхэд багачуудад толилуулав.

Хүчирхийллийг дуугүй өнгөрөөж болохгүй гэдэг үзэл санааг иргэдэд түгээх зорилгоор хүний наймааны золиос болсон хоёр бүсгүйн тухай өгүүлсэн **“Өглөөний нар”** 2 хүний жүжгийг анх удаа туурвиж 2 удаа тоглож, 780 хүнд үйлчилсэн.

Гэр бүлийн хүчирхийллийн гол шалтгаан бол **“ЭРХ МЭДЛИЙН ТЭНЦВЭРГҮЙ БАЙДАЛ ба ХЯНАЛТАНДАА БАЙЛГАХ** гэснээс үүдэлтэй гэдгийг илэрхийлсэн **“Хайрт минь энэ ердөө л эхлэл”** 1 хүний монодрам жүжгийг 3 удаа тоглож, 600 хүнд үйлчилсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор хүүхдийн хүчирхийллийн эсрэг болон архи, согтууруулах ундааны хор уршгийг хүүхэд залууст сурталчлан таниулах соён гэгээрүүлэх зорилготой Тоонот рекордс уран бүтээлийн нэгдлийн **“Тоонот 21*21”** тоглолтыг зохион байгууллаа.

Соёлын байгууллагууд улс орон даяар өрнөж буй Зөвийг зөвлөө, Аажуу явбал аяндаа хүрнэ дээ, Замын хөдөлгөөний аюулгүй байдал, “Замын хөдөлгөөнд Хүүхэд нэгдүгээрт”, Хүүхдийг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зэрэг аяны хүрээнд постер, уриалгыг хийж Соёл, урлагийн газрын болон соёлын байгууллагуудын цахим хуудсанд байршуулж олон нийтэд уриалсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 43 дугаар зарлигт тусгагдсан хорт зуршлаас ангид шинэ үеийг төлөвшүүлэх, согтууруулах ундааны хор уршиг, сөрөг нөлөөг сурталчлан таниулах чиглэлээр архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх **“Намайг алгас”** ухуулга нөлөөллийн аянд аймгийн Соёл, урлагийн газар, соёлын байгууллагууд нэгдсэн.

4.2. Жендерийн тэгш байдлыг хангах, тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн иргэдэд соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар;

➤ Соёлын байгууллагууд ажилтнуудын жендерийг тэнцвэржүүлэхэд анхаарч байна. Нийт соёлын байгууллагын албан хаагчдад жендерийн эрх тэгш байдлын талаар сургалтыг 3 удаа зохион байгуулсан.

➤ **СОЁЛЫН САЛБАР ДАХЬ ЖЕНДЭРИЙН АСУУДАЛ**” эрдэм шинжилгээний хуралд Аймгийн Төв номын сангийн ахлах номын санч Г.Нямцэнд "Жендерийн тухай иргэдийн ойлголт, хандлага" сэдвээр илтгэл тавьж, амжилттай оролцсон ба тус эрдэм шинжилгээний хурлаар соёлын салбарт жендерийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой асуудлуудыг цаашид гүнзгийрүүлэн судлах эхлэл тавигдах юм.

➤ “Нандин бүхнээ хамгаалъя – өөрийгөө, гэр бүлээ, орчин тойрноо” уриатай үндэсний хэмжээний Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянд аймгийн Соёл, урлагийн газар, соёлын байгууллагууд нэгдсэн. Соёл, урлагийн байгууллагын 20 албан хаагчаас Жендерийн асуулгын үнэлгээний судалгаа авч Соёлын яаманд цахимаар болон албан бичгээр хүргүүлсэн.

➤ Нийгмийн хариуцлагын хүрээнд зорилтод бүлэгт чиглэсэн тоглолт хийж ШШГГ-ын харьяа 445 ангийн хүмүүжигчдийг 100% хамруулж үйлчилсэн.

➤ “Хараацай, Хэдгэнэ 2” хүүхдийн жүжгийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдөр 2 удаа үнэ төлбөргүй зорилтот бүлгийн хүүхэд багчуудад тоглож 600 гаруй хүүхэд хамрууллаа.

➤ “Шидэт модны үр” хүүхдийн жүжгийн нээлтэд зориулж 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр 150 ширхэг урилгыг зорилтот бүлгийн хүүхдүүдэд бэлэг болгон барилаа.

➤ Аймгийн музей нь 2020 оноос хойш хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан брайл үсгийн тайлбартайгаар музейн үзмэрийг үзүүлж үйлчилж байна.

4.3. Санхүү, хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтийн чиглэлээр;

➤ Тус газарт 2022 онд улсын төсвөөс 210,861,100 төгрөгийн санхүүжилт баталж өгсөн. Үүнээс 2022.12.15-ны өдрийн байдлаар нийт 210,861,100 төгрөгийн санхүүжилт авч, 66,975,400 төгрөгийг зүйл тус бүрээр зориулалтын дагуу зарцуулсан.

➤ **Батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан зардлын задаргааг авч үзвэл:**

1. Ажилчдын цалин 45,569.1 мян. төгрөг буюу 21,6%
2. Нийгмийн даатгалд 5,696.1 мян. төгрөг буюу 2,7%
3. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2,200. мян. төгрөг буюу 1%
4. Хангамж, бараа материалын зардал 2,690,6 мян. төгрөг буюу 1,3%
5. Томиллолт, зочны зардал 2,010.0 мян. төгрөг буюу 0,9%
6. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 4,696.2 мян. төгрөг буюу 2,2%
9. Бараа үйлчилгээний бусад зардал 4,013,4 мян. төгрөг буюу 1,9%
10. Ажил олгогчоос олгох тэтгэмж 100.0 мян. төгрөг буюу 0,04%-ийг тус тус эзэлж байна.

➤ Төсвийн ил тод байдлын самбарт сар бүрийн төсвийн гүйцэтгэлийг нийтдээ 12 удаа шинэчлэн байршуулж, Шилэн дансны тухай хууль батлагдсантай холбогдуулан гүйлгээ хийсэн тухай бүрд цахим санд нийтдээ 18 мэдээллийг оруулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан.

➤ Сангийн яам, Дэлхийн Банк хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь Засаглалыг Бэхжүүлэх” төслийн хүрээнд хөгжүүлж буй Шилэн дансны шинэчилсэн нэгдсэн цахим хуудсанд хэрэглэгчийн эрхийг бүртгүүлж мэдээллийг оруулсан.

➤ 2022 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор 31 нэр төрлийн 30,236,701 төгрөгийн өртөгтэй 912,443 төгрөгийн хуримлагдсан элэгдэлтэй хөрөнгө тоологдсон байна.

Салбарын санхүүгийн нөөц:

/2022 оны батлагдсан төсөв/

№	Байгууллагын нэр	Тоо	Жилийн төсөв
1	Соёл, урлагийн газар	1	210,861,100.00
2	Залуучууд театр	1	1,453,156,300.00
3	Номын сан	1	280,020,900.00
4	Музей	1	148,700,100.00
5	Хүүхдийн номын ордон	1	279,500,100.00
6	Орхон сумын Соёлын төв	1	101,632,000.00
7	Шарын гол сумын Соёлын төв	1	131,881,500.00
8	Хонгор сумын Соёлын төв	1	94,031,300.00
	Нийт	8	2,699,783,300.00

➤ 2022 онд соёл, урлагийн байгууллагуудын урсгал санхүүжилт орон нутгийн төсвөөс улсын төсөвт шилжснээр өөрийн орлогыг үндсэн үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөнд тусгахгүй өөрсдөө зарцуулдаг болсон нь төсөв хүрэлцэхгүй, дутагдалтай зардлуудаа шийдэхэд давуу тал болсон.

Соёлын байгууллагуудын 2022 оны төсвийн Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл

Соёлын байгууллагын нэр	Төлөвлөгөө /Үйл ажиллагаа/		Гүйцэтгэл /Үйл ажиллагаа/		Биелэлт Хувь
	Үндсэн	Туслах	Үндсэн	Туслах	
Залуучууд театр	20,000,000	70,000,000	18,021,200	71,471,400	99.4
Номын сан	5,000,000		2,769,900		55.4
Музей	5,000,000		3,300,000		66
Хүүхдийн номын ордон	6,500,000		6,808,500		105
Орхон сумын Соёлын төв	3,780,000	7,309,700	847,400	3,792,995	42
Шарын гол сумын Соёлын төв	3,000,000		-	-	-
Хонгор сумын Соёлын төв	3,000,000		-	-	-
	46,280,000	77,309,700	31,747,000	75,264,395	

➤ Соёл, урлагийн газрын хагас жилийн санхүүгийн тайлан, харъяа 7 байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайланг 8 дугаар сарын 02, 03-ны өдрүүдэд Соёлын яамны Санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргэн ажилласан.

➤ Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу 2022 оны 3 дугаар улирлын тайланг Э-Тайлан системд нэгтгэсэн. 2022 оны жилийн эцсийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн хугацаанд нь гаргаж аудитын дүгнэлт гаргуулан холбогдох байгууллагуудад хүргүүлэхээр ажиллаж байна.

➤ Тайлант оны жилийн эцсийн байдлаар Орхон сумын ОНХС-ийн 285,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тус сумын Соёлын төвийн барилгын 2 дугаар давхрын 600 м.кв талбайн их засварыг “БДЗ ХХК” хийж гүйцэтгэн 2022 оны 08 дугаар сарын 31-нд ашиглалтад оруулж комисст хүлээлгэн өгөв.

➤ Шарын гол сумын Соёлын төвийн дотор засварыг ОНТ-ийн 181,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Чонотдеволупмент” ХХК хийж гүйцэтгэн 11 дүгээр сарын 30-нд дуусган комисст хүлээлгэн өгөв. Улмаар сумын Соёлын төвийн орон нутаг судлах танхимыг улсын төсвийн 76.4 сая төгрөгөөр гүйцэтгэхээр ажлыг эхлүүлсэн. Хүйтний улирал эхэлсэнтэй холбоотой ажил түр зогссон. Мөн энэ онд Шарын гол сумын Соёлын төвд 34,8 сая төгрөгөөр Лэд дэлгэц, 10,0 сая төгрөгөөр хөгжим техник, 53,0 сая төгрөгөөр гадна фасадын ажил, 47,0 сая төгрөгөөр дээврийн засвар, 30,0 сая төгрөгөөр сантехник, 14,0 сая төгрөгөөр ариун цэврийн өрөөний засварын ажлыг тус тус хийж гүйцэтгэн хүлээлгэн аймаг, сумын болон аж ахуйн нэгж байгууллагын дэмжлэгээр нийт 419,000.000 сая төгрөгийн засвар үйлчилгээ, хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн.

➤ Орхон сумын Соёлын төв нь тус онд ОНХС-гийн 285 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2 давхраа засварласан. Орон нутгийн судлах танхимыг тохижуулах зураг батлагдсан. Тохижилтын зардлыг 2023 орон нутгийн төсөвт суулгаж хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

➤ Залуучууд театрт Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 99 487 000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ. Үүнд: Дуу шумны хөгжим худалдан авах 79 500 000, Уран бүтээлийн хувцас хийх 19 987 000 төгрөг. Дууны тоног төхөөрөмжийг тендерт шалгарсан компани нийлүүлэхийг хүлээж байна. Оndoо багтана.

➤ Музей-Номын Сангийн цогцолбор 2021-2023 онд нийт 14,533,0 тэрбум төгрөгөөр баригдах бөгөөд 2022 онд барилгын эхний үе шатны ажлыг “Бокон” ХХК гүйцэтгэсэн. Эхний үе шатны ажил буюу суурийн ажил 100%-ийн гүйцэтгэлтэй байна. 1 давхарын угсралтын ажил дууссан.

➤ Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн Соёлын салбарын 7 байгууллагын 2023 онд шаардлагатай байгаа их засвар тоног төхөөрөмжийн судалгааг авч нэгтгэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 1,4 тэрбум төгрөгийн саналыг 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 02 дугаар албан тоотоор, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 301,5 сая төгрөгийн саналыг 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 141

тоот албан бичгээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлэн ажиллалаа.

4.4. Оюуны өмчийн хамгааллын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр;

➤ Тус аймагт үйл ажиллагаа явуулдаг Титанс кино студи нь “Богд эзний зарлигаар” түүхэн кино зохиол бичиж, Оюуны өмчид бүртгүүлэхээр материалыг бүрдүүлж байна.

➤ Орон нутагт оюуны өмчийн эрхээр хамгаалагдах бүтээл, оюуны өмчийг хамгаалах зарчим, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, дэмжих үйл ажиллагааний хэрэгжилт хангалтгүй байгаа тул мэргэжлийн урлагийн байгууллага болон уран бүтээлчдийг сургалтад хамруулах шаардлага үүсч байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

Төсвийн шууд захирагч:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН:...../Х.СОЁЛ-ЭРДЭНЭ /

ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

(албан тушаал)

(гарын үсэг)

(гарын үсгийн тайлал)

(тэмдэг)

.....

(огноо)

ДЭЛГЭРЭХ СОЁЛЫН ГАРААНД